



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 24 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 30 дугаар захирамжаар батлагдсан санхүүжилтээр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилт хангах зорилгоор Нийслэлийн прокурорын газарт 1 ширхэг автомашин олж авахыг зөвшөөрч, техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор Ш.Нямдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000661

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 07 дугаар сарын 06 ны өдрийн  
406 дугаар тогтоолын хавсралт



Нийслэлийн прокурорын газрын олж авах автомашины  
техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

| Д/д | Хөрөнгийн нэр                                                            | Нэг бүрийн<br>үнэ (төгрөг) | Тоо<br>ширхэг | Худалдан авах үнийн дээд<br>хязгаар (төгрөг) |
|-----|--------------------------------------------------------------------------|----------------------------|---------------|----------------------------------------------|
| 1   | Суудлын,<br>хөдөлгүүрийн<br>багтаамж 3000 cc<br>хүртэл,<br>суудлын тоо 5 | 80,000,000.00              | 1             | 80,000,000.00                                |
|     | <b>Нийт дүн</b>                                                          |                            |               | 80,000,000.00<br>/наян сая/                  |